

Хавсралт

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлт

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх, Монгол Улс болон Польш Улс хоорондын эдийн засгийн үр дүнтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн дагуу дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулав.

- 1) 1 дүгээр зүйлийг "Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар Монгол Улсын хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсролын шинэчлэл, байгаль орчин хамгаалал болон эрүүл мэндийн үйлчилгээний салбарын төслийн санхүүжилтэд зориулан 50 сая (тавин сая) хүртэлх еврогийн зээлийг (цаашид "зээл" гэх) Монгол Улсын Засгийн газарт олгоно. Энэхүү зээлийг Польш Улсаас Монгол Улсад нийлүүлэх бараа, үйлчилгээний гэрээний үнийн дүнг 100% (зуун хувь) санхүүжүүлэхэд ашиглана. Хавсралтад зээлийн хүрээнд санхүүжүүлэх төслийг тодорхой тусгах бөгөөд энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна." гэж өөрчлөх.
- 2) 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг "Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан гэрээг Монгол Улсын импортлогч болон Бүгд Найрамдах Польш Улсад байршилтай үйлдвэрлэгч (цаашид "Польшийн үйлдвэрлэгч" гэх) нарын хооронд 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрөөс өмнө байгуулна." гэж өөрчлөх.
- 3) зээлийн хүрээнд санхүүжүүлэх төслийг тодорхойлсон хавсралт гэх нэр, томъёоллыг энэхүү хавсралтад нэмнэ.

2 дугаар зүйл

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу батлагдах бөгөөд энэ тухайгаа ноот бичиг солилцон баталгаажуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2019 оны 5 сарын 2 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

оруулах тухай хавсралт нь сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хүлээсэн бүх үүрэг биелэгдэх хүртэл хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ. _

.....хотнооөдөр монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Эх бичвэрүүдийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эхийг баримтална.

Монгол Улсын Засгийн
газрыг төлөөлж

Бүгд Найрамдах Польш Улсын
Засгийн газрыг төлөөлж




Хавсралт

Энэхүү хавсралтын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсан Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн дагуу санхүүжүүлэх төсөл:

№	Төсөл арга хэмжээ	Дүн сая нэгж /EUR/
1	"Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих" төсөл. 1.1 Баян-Өлгий аймаг Өлгий сум 1.2 Говьсүмбэр аймаг Чойр сум 1.3 Дорнод аймаг Чойбалсан сум 1.4 Завхан аймаг Улиастай сум 1.5 Увс аймаг Улаангом сум	17.5
2	"Гал түймэртэй тэмцэх техник тоног төхөөрөмжийг шинэчлэх" төсөл	3.0
3	"Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт эмнэлэг" төсөл	6.5
4	"Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төсөл	10.2
5	"Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төсөл	9.0
6	"Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглодсон автомашин ханган нийлүүлэх" төсөл	3.8
	Нийт дүн	50.0

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Г.рын үсэг /Signature/

2018 оны 12 сарын 22 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION 1